



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/269

Хэрлэн сум

Үндэсний сурын нээлтийн тэмцээн
зохион байгуулахад дэмжлэх үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.2.1 дэх "Монгол үндэсний уламжлалт морь, бөх, сур, шагайн спортын арга хэмжээг жил бүр зохион байгуулж хэвшинэ" заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2024 оны Үндэсний сурын нээлтийн тэмцээнийг зохион байгуулахад 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Монгол үндэсний уламжлалт морь, бөх, сур, шагайн спортын арга хэмжээг жил бүр зохион байгуулж хэвшинэ" арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ